



САВХАН БҮЖГИЙН СУРГАЛТЫН БАГА АНГИЙН СУРАГЧДЫН СОЁЛЫН ОЙЛГОЛТ БА ОРОЛЦООНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

А.Оюунтунгалаг^а, WUYUNDARI^б

^а МУБИС-Багшийн сургууль, дэд профессор, доктор;

^б БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын Үндэстний туршилтын
бага сургуулийн багш, МУБИС-ийн магистр

Холбоо барих зохиогч: oyuntungalaga@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2025.09.03

Хянагдсан: 2025.10.03

Зөвшөөрсөн: 2025.11.10

Хураангуй

Энэхүү судалгааны ажил нь Өвөр Монголын ардын уламжлалт савхан бүжгийг бага ангийн сурагчдын сургалт, хүмүүжил, соёлын ойлголтод нэвтрүүлэх замаар түүний боловсролын ач холбогдлыг тодорхойлох зорилготой юм. Судалгаанд Хөх хотын Үндэстний туршилтын сургуулийн 1–2 дугаар ангийн нийт 156 сурагч оролцсон бөгөөд тэд 15 долоо хоногийн турш савхан бүжгийн хөтөлбөрт хамрагдсан. Туршилтын өмнөх ба дараах асуулга, ажиглалт, үнэлгээний дүнгээс харахад сурагчдын оролцоо, урам зориг, хамтын ажиллагаа, биеийн уян хатан байдал, соёлын ухамсар мэдэгдэхүйц сайжирсан байна. Энэхүү арга нь бага ангийн сургалтад соёлын өвийг уялдуулан хэрэгжүүлэх, уламжлуулах үр дүнтэй хэлбэр болохыг нотолж байна.

Түлхүүр үг

Савхан бүжиг, бага анги, өв соёл, боловсрол судлал, туршилтын сургалт

Удиртгал

Сүүлийн жилүүдэд боловсролын чанарыг сайжруулах нэг чиглэл нь сургалтад үндэсний өв соёлыг уялдуулах асуудал болж байна. Монгол үндэстний уламжлалт бүжгийн хэлбэрүүдийн дундаас савхан бүжиг нь хөдөлгөөний зохицол, гоо зүйн илэрхийлэл, хамтын оролцоог илтгэдэг өвөрмөц хэлбэр юм. 2008 онд савхан бүжиг нь Өвөр Монголын Өөртөө Засах Орны биет бус соёлын өвийн жагсаалтад орсон бөгөөд түүний сурган хүмүүжүүлэх үнэ цэн, ялангуяа бага боловсролын түвшинд хэрэглэх боломж чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Арга зүй

Судалгаанд 156 сурагч (1–2-р анги) оролцсон бөгөөд тэдний дундаас 20 сурагчийг сонгон туршилтын бүлэг болгон авсан. Савхан бүжгийн сургалтыг 15 долоо хоногийн турш хэрэгжүүлж, долоо хоногт 2 удаа 15–20 минутын хичээл хэлбэрээр явуулсан. Судалгаанд туршилтын өмнөх ба дараах үзүүлэлтийг харьцуулан тоон болон чанарын үнэлгээ хийсэн. Судалгаанд дараах аргуудыг ашиглав:

1. **Ажиглалт** – сурагчдын оролцоо, хичээл зүтгэл, хамтын ажиллагааг үнэлэх.
2. **Асуулга** – сурагчдын сэтгэл ханамж, хандлага, савхан бүжгийн талаарх ойлголтыг тодорхойлох.
3. **Үнэлгээний шалгуур:**
 - Хөдөлгөөний зохицол (0–5 оноо)
 - Хандлага, оролцоо (0–5 оноо)
 - Хамтын ажиллагаа (0–5 оноо)
 - Бүтээлч илэрхийлэл (0–5 оноо)
 - Соёлын ойлголт (0–5 оноо)

Судалгааны үр дүн

Бидний энэ судалгаа нь бүжиг судлал, соёл судлал, биеийн тамир, сэтгэл судлал, спортын шинжлэх ухаан, боловсрол зэрэг олон салбарын өргөн хүрээг хамарсан онцлогтой. Савхан бүжиг завсарлагааны дасгалаар сурагчдын оролцоо хичээл зүтгэл, багаар ажиллах хамтын ажиллагаа, гимнастикийн ур чадвар, бүтээлч байдал, илэрхийлэх чадварыг үнэлснээс гадна бидний судалгааны гол зорилго болсон ардын бүжгийн хөтөлбөр сурагчдад соёлын өвтэй холбоотой харилцааг хөгжүүлэх, олон янз байдлыг үнэлэх чадварыг хөгжүүлэхэд хэрхэн тусалдаг талаар гүнзгийрүүлэн судаллаа.

Бид энэхүү дасгал сургалтад хамрагдсан сурагчдаа үнэлэх тодорхой арга зам, шалгуурыг Чэнду Биеийн тамирын дээд сургуулийн профессорийн зохиосон шалгуур болон өөрийн багшлах, сурагчаа үнэлэх туршлагадаа тулгуурлан боловсрууллаа. Сурагчдыг оролцоо, багаар ажиллах, техникийн ур чадвар, бүтээлч байдал гэх зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж үнэлнэ. Сурагчдад зөвхөн бүжгийн техникийг төгс эзэмших бус хичээл зүтгэл гаргах, сайжруулалт хийх, багаар ажиллахад түлхэц өгөх, тэднийг дэмжиж хөгжүүлэх цогц үнэлгээг боловсруулахыг чармайсан. Энэ үнэлгээний загвар бүтэц нь бусад багш нарт сурагчдын гүйцэтгэлийг үр дүнтэй үнэлэх боломжийг олгоно гэж үзэж байна.

1. Туршилтын өмнөх ба дараах дүн

Хүснэгт 1. Сурагчдын оролцоо, чадвар, хандлагын ахиц

Үзүүлэлт	Туршилтын өмнө (дундаж оноо)	Туршилтын дараа (дундаж оноо)	Өөрчлөлт
Хөдөлгөөний зохицол	2.6	4.2	+1.6
Хандлага, оролцоо	2.8	4.5	+1.7
Хамтын ажиллагаа	2.7	4.3	+1.6
Бүтээлч илэрхийлэл	2.5	4.1	+1.6
Соёлын ойлголт	2.9	4.6	+1.7

Дүгнэлт: Туршилтын дараа бүх үзүүлэлт 1.5–1.7 оноогоор өссөн нь сурагчдын суралцах хандлага, соёлын ойлголт бодитоор сайжирсныг харуулж байна.


2. Сурагчдын хандлага, сэтгэл ханамж

Хүснэгт 2. Сурагчдын хандлага, сэтгэл ханамж

Хариулт	Туршилтын өмнө (%)	Туршилтын дараа (%)
Савхан бүжиг бүжиглэх дуртай	85.0	100.0
Савхаа зөв барьж чаддаг	70.5	100.0
Бие эвтэйхэн мэдэрсэн	68.0	92.3
Хөгжмөө дагах чадвартай	72.0	95.0
Бүтээлч илэрхийлэл гаргаж чадсан	60.0	87.5


Дүгнэлт: Сэтгэл ханамж, оролцоо, бүтээлч илэрхийлэлд 20–30 хувийн өсөлт гарсан.

График 1. Туршилтын өмнө ба дараах сурагчдын дундаж оноо



Үзүүлэлт	Өмнө	Дараа
Хөдөлгөөний зохицол	2.6	4.2
Хандлага, оролцоо	2.8	4.5
Хамтын ажиллагаа	2.7	4.3
Бүтээлч илэрхийлэл	2.5	4.1
Соёлын ойлголт	2.9	4.6

График 2. Сурагчдын сэтгэл ханамж ба оролцооны хувь хэмжээ



Үзүүлэлт	Туршилтын өмнө (%)	Туршилтын дараа (%)
Савхан бүжиг бүжиглэх дуртай	85	100
Савхаа зөв барьж чаддаг	70.5	100
Бие эвтэйхэн байгааг мэдэрсэн	68	92.3
Хөгжмөө дагах чадвартай	72	95
Бүтээлч илэрхийлэл гаргаж чадсан	60	87.5

Савхан бүжиг завсарлагааны дасгалд хамрагдаж байгаа сурагчдын үнэлгээ (Түүвэрлэсэн 20 сурагч)

Хүснэгт 3. Савхан бүжиг завсарлагааны дасгалд хамрагдаж байгаа сурагчдын үнэлгээ

№	Сурагчийн нэр код		Хэзээ	Оролцоо хичээл зүтгэл (40%)	Багаар ажиллах, хамтын ажиллагаа (25%)	Хэмнэл, бүжгийн техник (20%)	Гимнастикийн ур чадвар (10%)	Бүтээлч байдал, илэрхийлэх чадвар (5%)	Нэгдсэн үнэлгээ
	Сурагч дугаар	Нэр код		Үнэлгээ 1.6	Үнэлгээ 1.0	Үнэлгээ 0.8	Үнэлгээ 0.4	Үнэлгээ 0.2	
1.	001	A1	өмнө	1.6	1.0	0.8	0.3	0.2	3,9 А
			хойно	1.6	1.0	0.8	0.4	0.2	4,0 А
2.	002	A2	өмнө	1.2	1.0	0.6	0.4	0.45	3,65 В+
			хойно	1.6	1.0	0.4	0.2	0.2	4,0 А
3.	003	A3	өмнө	0.8	0.75	0.8	0.4	0.1	2,25 С
			хойно	1.2	1.0	0.4	0.2	0.1	2,9 В
4.	004	A4	өмнө	1.6	1.0	0.8	0.4	0.2	4,0 А
			хойно	1.6	1.0	0.8	0.4	0.2	4,0 А
5.	005	A5	өмнө	1.2	0.75	0.6	0.3	0.1	3,2 В
			хойно	1.6	0.75	0.8	0.3	0.1	3,55 А
6.	006	A6	өмнө	0.4	0.5	0.4	0.1	0.05	1,75 D
			хойно	1.2	0.75	0.4	0.2	0.1	2,65 В
7.	007	A7	өмнө	1.6	0.75	0.8	0.4	0.1	3,85 А
			хойно	1.6	1.0	0.8	0.4	0.2	4,0 А
8.	008	A8	өмнө	1.2	0.75	0.6	0.2	0.1	3,80 Б
			хойно	1.2	0.75	0.8	0.3	0.1	3,15 В+
9.	009	A9	өмнө	1.2	1.0	0.6	0.3	0.1	3,65 В+
			хойно	1.6	1.0	0.8	0.4	0.2	4,0 А
10.	010	A10	өмнө	1.2	0.75	0.6	0.3	0.1	3,2 В
			хойно	1.6	1.0	0.8	0.3	0.1	3,8 А
11.	011	A11	өмнө	0.8	0.5	0.4	0.2	0.1	2,2 С
			хойно	1.2	0.75	0.6	0.3	0.1	3,0 В+
12.	012	A12	өмнө	0.4	0.5	0.4	0.2	0.1	1,6 D
			хойно	0.8	0.75	0.6	0.3	0.1	2,55 В
13.	013	A13	өмнө	1.6	0.75	0.6	0.3	0.15	3,4 В+
			хойно	1.6	1.0	0.8	0.4	0.2	4,0 А
14.	014	A14	өмнө	1.6	1.0	0.8	0.4	0.2	4,0 А
			хойно	1.2	0.75	0.8	0.4	0.2	3,35 В+
15.	015	A15	өмнө	1.6	1.0	0.8	0.4	0.2	4,0 А
			хойно	1.6	1.0	0.8	0.4	0.2	4,0 А

16.	016	A16	өмнө	0.8	0.5	0.4	0.1	0.05	1.85 D
			хойно	1.2	1.0	0.6	0.3	0.1	3.2 B+
17.	017	A17	өмнө	1.2	1.0	0.6	0.4	0.15	3,65 B+
			хойно	1.6	1.0	0.8	0.4	0.2	4,0 A
18.	018	A18	өмнө	1.6	0.75	0.8	0.4	0.15	3,85 A
			хойно	1.6	1.0	0.8	0.4	0.2	4,0 A
19.	019	A19	өмнө	1.2	1.0	0.6	0.3	0.15	3,65 B+
			хойно	1.2	1.0	0.6	0.3	0.15	3,65 B+
20	020	A20	өмнө	0.4	0.25	0.2	0.1	0.05	1.0 D
			хойно	0.4	0.75	0.6	0.3	0.2	2.25 C

Дүн шинжилгээ

Судалгааны дүнгээс харахад савхан бүжгийг сургалтын хөтөлбөрт нэвтрүүлэх нь зөвхөн хөдөлгөөний ур чадвар бус, сурагчдын соёлын ухамсар, хамтын ажиллагаа, урам зориг, бүтээлч илэрхийллийг дэмждэг болохыг харууллаа. Энэ нь хүүхдийн нийгмийн харилцаа, гоо зүйн мэдрэмж, бие бялдар, сэтгэл зүйн тэнцвэрт байдалд нөлөөлж байна.


Дүгнэлт

Савхан бүжгийн сургалт нь бага ангийн сурагчдын бие бялдар, хөдөлгөөний зохицол, гоо зүй, хамтын ажиллагааг хөгжүүлэхийн зэрэгцээ үндэсний өв соёлыг ойлгож, хүндэтгэх ухамсрыг төлөвшүүлдэг болохыг нотоллоо. Энэхүү судалгааны үр дүнг боловсролын хөтөлбөрт ашиглах нь соёлын болон хүмүүжлийн ач холбогдол өндөртэй юм.

Ном зүй

1. Laban, R. (1950). *Laban Movement Analysis (LMA)*. London: Macmillan.
2. Жоу Чин (2015). Баруун хойд Хятадын ардын бүжгийн соёлыг танилцуулах шинэ сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх нь. Бээжин, Боловсрол хэвлэл.
3. He, B., & Sun, D. (2012). *Research on Inheriting National Dance Culture*. Shanghai: Cultural Studies Journal.
4. Qiuling, Z. (2012) “Sunshine Sports” өөрөө зохион байгуулсан дасгалуудыг бүтээх, дизайн. Орчин үеийн спортын шинжлэх ухаан, технологи. Тал 69-70.
5. Ши, Ш. (2015). Савхан бүжгийн хөгжил ба онцлог судалгаа. Өвөр Монголын их сургууль.
6. Wuyundari. (2024). Өвөр монгол ардын савхан бүжгийг бага ангийн сурагчдад заах арга зүйн туршилт судалгаа (БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын Үндэстний туршилтын сургуулийн жишээн дээр). Магистрын диплом. МУБИС.
7. Wuyundari. (2023). Бага ангийн завсарлагааны дасгалд савхан бүжгийг нэвтрүүлэх судалгаа. Хөх хот: Үндэстний туршилтын сургууль.

“THE IMPACT OF STICK DANCE INSTRUCTION ON ELEMENTARY SCHOOL STUDENTS CULTURAL AWARENESS AND PARTICIPATION”

^aOyuntungalag A., ^bWuyundari
^aPhD., associate professor, Teachers School, MNUE;
^bLecturer, National Experimental School, Hohhot, China
Corresponding author: oyuntungalaga@msue.edu.mn 

Abstract

This study explores the educational impact of integrating the traditional Mongolian “Stick Dance” into primary school curricula in Inner Mongolia. A total of 156 students from Grades 1–2 participated in a 15-week program designed to promote cultural understanding and physical coordination. Pre- and post-tests revealed significant improvement in participation, creativity, teamwork, and cultural awareness. Quantitative results indicated 20–30% growth in positive attitudes and over 1.6 points increase in performance scores. The findings suggest that the Stick Dance serves not only as a physical activity but also as an effective pedagogical tool for fostering aesthetic appreciation and cultural identity among young learners. Integrating such cultural practices into basic education contributes to sustainable cultural preservation and holistic child development.

Keywords

Stick dance, cultural awareness, primary education, physical coordination, experimental teaching
